

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

03.09 - 03.13



Ковид-19-ийн тархалттай холбоотойгоор улс орнуудын Төвбанкны зүгээс авч буй арга хэмжээний тухай шинжээчийн булангаар хүргэж байна.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт шинэ төрлийн коронавирусын дэлгэлттэй холбоотой АНУ-ийн хөрөнгийн зах зээлийн индексүүд түүхэн дээд хэмжээний бууралттай хаагдлаа. Зах зээлийн томоохон индексүүдийн бууралтаас үүдэн хөрөнгийн зах зээл уналтад орлоо. Dow Jones үйлдвэрлэлийн дундаж индекс хамгийн сүүлийн дээд ханшнаасаа Пүрэв гарагт 28%-аар буурсан бол S&P 500 индекс 27% буурсан байна. Хөрөнгийн зах зээл ийнхүү уналтад орсон нь түүхэнд хамгийн хурдацтай уналт байсан ба 2-р сарын дунд үед түүхэн дээд ханшид хүрээд байсан индексүүд Пүрэв гарагт 1987 оноос хойших хамгийн өндөр нэг өдрийн бууралт үзүүлээ. Cboe Volatility Index (VIX) нь 2008 оны санхүүгийн хямралаас хойш хамгийн дээд хэмжээнд хүрсэн бөгөөд S&P 500 индекс 7%-аас дээш унасан үед хэрэгжүүлдэг арилжааг зогсоох арга хэмжээг 1997 оноос хойш анх удаа Даваа болон Пүрэв гарагт хэрэгжүүлжээ.

S&P 500 индексэд багтах бүх салбарын компаниудын ханш уналттай байсан бол эрчим хүчний салбарын компаниуд газрын тосны ханш буурсантай холбоотой хамгийн их бууралт үзүүлээ. Эрүүд мэнд, технологи болон харилцаа холбооны салбарын компаниудын ханш хамгийн сайн үзүүлэлттэй байлаа. Компаниуд болон хувь хүмүүс төлөвлөгдсөн байсан аялал болон арга хэмжээнүүдээ цуцалж буйгаас үүдэн холбогдох салбарууд хамгийн их хохирол амсаж байна.

Европ: Коронавирусын тархалт, АНУ-аас Европоос ирэх иргэдийн урсгалын хязгаарлах шийдвэр, ОПЕК болон ОХУ-ын үл ойлголцлоос үүдсэн газрын тосны үнийн огцом уналт мөн сангийн бодлогын арга хэмжээнүүд хүлээлтэд хүрээгүй зэрэгтэй холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналтад орлоо. Ихэнх гол индексүүд болох STOXX Europe 600 индекс, Их Британи, Франц, ХБНГУ, Италийн улсуудын индексүүд тус бүр 15%-аас 20% хүртэл буурчээ.

Европын Төв Банкнаас (ЕТБ) евро бүсийн эдийн засагт коронавирусын тархалттай холбоотой үүсэж буй хохирлыг даван туулахад зорилгоор эдийн засгийг дэмжих бодлого хэрэгжүүлсэн ч бодлогын хүүг хэвээр үлдээсэн нь хөрөнгө оруулагчдын хүлээлтэд хүрээгүй байна. ЕТБ нь банкнуудад шинэ зээл олгож, хөрвөх чадварын нөхцөлүүдийг илүү таатай болгож, нийт хөрөнгөө жилийн эцэс хүртэл түр хугацаанд 120 тэрбум еврогоор нэмэгдүүлнэ гэж мэдэгдсэн байна.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд сүүлийн гурван жилийн хугацаанд ажиглагдаагүй доод түвшинд хүрэв. Ихэнх ажиглагчид Японы Банк 3-р сарын 18-19-ний өдрийн мөнгөний бодлогын хорооны хурлаар мөнгөний бодлогыг сулруулна гэж таамаглаж байна. Хувьцааны ханшийн бууралт, иений ханш чангарсан, коронавирусын тархалт зэрэг нь Япон улсын бизнесийн хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж эдийн засгийн сэргэлтийг сулруулж болзошгүй юм.

БНХАУ: Дэлхийн санхүүгийн хямралаас хойших зах зээлийн хамгийн тогтворгүй нөхцөл байдал үүссэн хэдий ч Shanghai Composite индекс 4.8%, CSI 300 индекс 5.9% буурчээ. БНХАУ дэлхийн коронавирусын тохиолдлын дийлэнх хувийг эзэлж, эдийн засаг нь 2-р сарын турш зогсонги байдалд орсон ч Shanghai Composite индексийн бууралт MSCI Бүх Улс Орны Индексийн бууралттай ойролцоо байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,606.08	-1.30% ▼
Dow Jones	АНУ	23,185.62	-10.36% ▼
S&P 500	АНУ	2,711.02	-8.79% ▼
Nasdaq	АНУ	7,874.88	-8.17% ▼
S&P/TSX	Канад	13,716.33	-15.20% ▼
FTSE 100	Их Британи	5,366.11	-16.97% ▼
S&P/ASX 200	Австрали	5,539.30	-10.89% ▼
Nikkei 225	Япон	17,431.05	-15.99% ▼
Hang Seng	Хонг Конг	24,309.07	-7.03% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	98.45
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	90.15
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	90.02
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	99.08
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.33
DBM' 2023	USD	7.250%	104.63
TDBM' 2020	USD	9.375%	99.49
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	91.30

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.800	-0.06 ▼
Libor 3M	0.840	-0.06 ▼
Libor 6M	0.820	-0.06 ▼
Libor 1YR	0.822	-0.02 ▼
US 2YR Bond	0.270	-0.06 ▼
US 3YR Bond	0.330	-0.05 ▼
US 5YR Bond	0.411	-0.02 ▼
US 10YR Bond	0.673	0.14 ▲

Валютын ханш	2020.03.13	Өөрчлөлт
USD	2,767.52	0.11% ▲
CNY	396.07	-0.46% ▼
EUR	3,096.72	-0.35% ▼
RUB	37.90	-7.43% ▼
KRW	2.27	-2.16% ▼
JPY	26.15	0.08% ▲
CAD	1,998.93	-3.11% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,529.83	-8.60% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	14.72	-15.15% ▼
Зэс	USD/lb.	246.40	-3.77% ▼
Нүүрс	USD/MT	65.60	-1.01% ▼
WTI газрын тос	USD/bbl.	31.73	-23.13% ▼
Brent газрын тос	USD/bbl.	33.85	-25.23% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. I	5.6%
Бодлогын хүү	2020. I	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. I	10.86 %
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. I	11.42%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. I	4.74%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. I	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. I	10.30%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 483 компанийн 448.6 сая төгрөгийн 1,394,833 ширхэг хувьцаа арилжаалагдав.

"Монгол даатгал" /CHE/ компанийн хувьцаа 26.05%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,500.00 төгрөг хүрч хаагдсан бол "Жуулчин дютти фрий" /SUL/ компанийн хувьцаа 16.82%-аар буурч 73,200.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

03-р сарын 13-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,736.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,606.08 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.30%-аар буурсан байна.



Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	448.6	
Зах зээлийн үнэлгээ	2,736,103.8	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,606.08	-1.30% ▼
MSE I индекс	9,031.30	-1.74% ▼
MSE II индекс	7,722.98	-0.14% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Инвекор ББСБ	64,074	165,316,954
Ард санхүүгийн нэгдэл	46,248	67,344,798
АПУ	61,072	39,155,789
Ард кредит ББСБ	420,433	30,812,696
Ард даатгал	43,033	30,013,386

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монгол даатгал	1,500.00	26.05% ▲
Гутал	17,550.00	15.08% ▲
Хар хорум пропертийс	89.70	15.00% ▲
Түшиг уул	600.00	10.14% ▲
Ард санхүүгийн нэгдэл	1,583.00	7.76% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Жуулчин дютти фрий	73,200.00	-16.82% ▼
Баянтээг	25,000.00	-12.28% ▼
Эрдэнэ ресурс девелопмент корп	480.00	-9.43% ▼
Бөхөг	1,500.00	-9.09% ▼
Лэндмн ббсб	34.98	-7.29% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Инвекор капитал	298,689,368
Ард секюритиз	286,455,842
Ти Ди Би Капитал	86,391,626
Стандарт Инвестмент	38,628,578
Би Ди Сек	27,400,773

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	640.18	681,268
Таван толгой	6,500.00	342,324
МИК Холдинг	14,400.00	298,214
Инвекор ББСБ	2,609.00	187,138
Говь	211.00	164,604

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	NA	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	NA	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	NA	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	NA	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	NA	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	NA	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	NA	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	NA	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	NA	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	NA	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
30	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	NA	2020.05.01-ЭЭС

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ



Шинэ төрлийн корона вирус (Covid 19)-ын халдвар эрчимтэй тархаад буй энэхүү үед Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалтын байгууллагуудад халдварт өвчний эрсдэлээс албан хаагчдаа хамгаалан, халдварт өвчин, хорио цээрийн улмаас зах зээлд үүсээд буй хүндрэлийг даван гарах нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан чанд мөрдөж ажиллахыг зөвлөн “Харвардын бизнесийн тойм”, АНУ-ын “Халдварт өвчлөлийг хянах, урьдчилан сэргийлэх төв”-өөс гаргасан халдварт өвчлөлийн үед бизнес, санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаандаа дагаж мөрдөх зөвлөмжийг гаргасан байна.

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

- “Хар хорум пропертийс” ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээх тухай Санхүүгийн Зохицуулах Хорооны Улсын байцаагчийн 2020 оны 3-р сарын 12-ны өдрийн 51 тоот албан шаардлагын дагуу арилжааг 2020 оны 3-р сарын 13-ны өдрөөс нээлээ. Тус компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан үнэт цаасны арилжааг 2019 оны 1-р сарын 02-ны өдрөөс эхлэн түр зогсоогоод байсан билээ.
- “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК нь Монгол улсын “Ашигт Малтмал Газрын Тосны Газар”-аас Хөндийн ордын өндөр агуулга бүхий нөөц агуулсан Алтан Нар төсөлд MV-021547 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгосон ба үргэлжлүүлэн 70 жил хүртэл сунгах боломжтой.



БУСАД МЭДЭЭ

Монголын хөрөнгийн зах зээлд олон улсын жишигт нийцсэн Миллениум Ай Ти цогц систем 2012 онд нэвтэрснээр харилцагчид онлайн арилжаанд орох, арилжааны хяналтыг бодит цагийн горимоор хийх, арилжаа болон захиалгын олон шинэ төрлүүдийг зах зээлд нэвтрүүлэх боломжууд бүрдсэн билээ.

2013 оноос өмнө хөрөнгө оруулагчид арилжаанд оролцохдоо харилцдаг үнэт цаасны компани буюу брокерт телефон утсаар эсвэл биеэр очин захиалга өгдөг байсан бол тус систем нэвтэрснээр хөрөнгө оруулагчид гар утас, компьютер, таблет гэх мэт дурын цахим төхөөрөмж ашиглан арилжаанд шууд орж эхэлсэн бөгөөд жил ирэх тусам онлайн арилжаанд оролцогчдын тоо эрчимтэй өсч байна. Тухайлбал, өнгөрсөн 2019 онд Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцож буй хөрөнгө оруулагчдын (давтагдаагүй тоогоор) 32.5 хувь нь онлайн арилжаанд оролцож байсан бол 2020 оны 3 дугаар сарын байдлаар нийт хөрөнгө оруулагчдын 49.2 хувь нь МХБ-ийн гишүүн 8 үнэт цаасны компаниар зуучлуулан онлайн арилжаанд оролцож байна.

Ийнхүү, хөрөнгө оруулагчид онлайн арилжаанд оролцох болсноор хугацааны хоцрогдолгүйгээр оролцох, зардал буурах, хугацаа хэмнэгдэх зэргээр зах зээлийн үр ашиг сайжирч байгаа бөгөөд цаашид тус системийн бусад функцүүдийг ашиглалтанд оруулж, хөрөнгө оруулагчдын өгөөжийг нэмэгдүүлэх, зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулахаар ажиллаж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

- Мөнгөний бодлогын хүүг 10 хувь болгож буурууллаа.
- Монголбанкны худалдан авсан үнэт металл 4.9 тоннд хүрэв.
- “Covid-19”-ийн сөрөг нөлөө 6 сар хүртэл үргэлжилбэл ДНБ-ий өсөлт огцом саарах таамаглалыг Монголбанк гаргажээ.
- Инфляц 4 сар дараалан төв банкны зорилтоос бага гарч эдийн засгийн идэвхжил буурсныг дахин илтгэлээ.
- Монголбанк ирсэн саналыг 100 хувь биелүүлж 36.3 сая ам.доллар валютын захад нийлүүллээ.



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 3-р сарын 11-ний өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоох болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөх шийдвэр гаргалаа.

Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлс болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан Мөнгөний бодлогын хорооноос санхүүгийн зуучлалыг дэмжих, банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх зорилгоор бодлогын багц шийдвэр гаргав.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголбанк 2020 оны 03-р сарын 11-ний өдрийн байдлаар нийт 4.9 тн үнэт металл худалдан авсан бөгөөд үүнээс алт 3.2 тн, цагаан мөнгө 1.7 тн худалдан авсан нь өмнөх оны мөн үед 1.2 тн үнэт металл худалдан авч байснаас 3.7 тонноор өссөн байна.

Үнэт металлын худалдан авалт өсөхөд дэлхийн зах зээлийн алтны үнэ өссөн, өнгөрсөн оны мөн үед холбогдох хууль шинэчлэн батлагдах хугацаанд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 10 хувиар тооцон суутган авч байсан, он гарсаар дотоодын аж ахуйн нэгжээс 1.7 тн цагаан мөнгө худалдан авсан зэрэг өөрчлөлт нөлөөлжээ

Монголбанкны дотоодын зах зээлээс худалдан авах 1 грамм алтны дундаж үнэ 2020 оны 2-р сард дунджаар 140,292.94 төгрөг байв. Харин 2020 оны 3-р сарын 11-ний өдрийн байдлаар зарласан үнэ 1 гр алт 147,096.92 төгрөг, 1 гр мөнгө 1,492.43 төгрөг тус тус байна.



ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

КОВИД-19 БА БОДЛОГЫН ХҮҮ


Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 03-р сарын 11-ний өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоох болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөх шийдвэр гаргалаа.

Энэ нь 2018 оны 11-р сарын 28-ны өдрөөс хойших бодлогын хүүг өөрчилсөн анхны шийдвэр байсан ба Монголбанк хүүг бууруулах шийдвэрийг, Ковид-19 вирусийн тархалттай холбоотой тодорхой бус байдал нэмэгдэж байгаагаас гадаад эрэлт, түүхий эдийн үнэ буурч, гадаад болон дотоод эдийн засгийн идэвхжил сулран, эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарах эрсдэлийг бий болгож байгаа ба цаашид эдийн засагт үзүүлэх нөлөө нь Ковид-19 вирусийн тархах цар хүрээ болон үргэлжлэх хугацаа, вирусийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс ихээхэн хамаарахаар байна гэж тайлбарласан.

Мөн вирусийн тархалттай холбоотойгоор 2020 оны 03-р сарын 03-ны өдөр АНУ-ын Холбооны Нөөцийн Сан (ХНС) бодлогын хүүг 0.5 нэгж хувиар буулгаж 1.25% хувь болгосон байсан бол вирусийн тархалт АНУ-д улам идэвхжиж байгаатай холбоотой 2020 оны 03-р сарын 15-ны өдөр бодлогын хүүг дахин 1.0 нэгж хувиар бууруулах гэнэтийн шийдвэрийг гаргалаа.

Вирусийн тархалт улс орнуудын эдийн засагт сөргөөр нөлөөлж байгаа ба үүний эсрэг арга хэмжээг улс орнуудын Төв банкууд бодлогын хүүг буулгах замаар шуурхай авч хэрэгжүүлж байна. Бодлогын хүүг бууруулах нь зах зээлд бэлэн байгаа мөнгөний хэмжээг нэмэгдүүлэн эдийн засгийг идэвхжүүлэх нөлөөг үзүүлдэг ба Төв банк мөнгөний бодлогын үзэл баримтлалыг илтгэгч үндсэн хэрэгсэл юм.

Зураг 1. Монголбанкны бодлогын хүүгийн түүхэн үзүүлэлт



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.